ДУНДГОВЬ АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТЭС
48090 Мандалговь, Сайнцагаан сум,
Утас, Факс: 7059-3033
E-mail: dundgobi@mta.mn

2021.09.23 № 08/459.

танай ______________ -ны №______________-т

ТЕГ-ын санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст

Нэмэлт санхүүжилт хүсэх тухай

Тус Татварын хэлтсийн эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж ирсэн ба сүүлийн хагас жилд байр ашиглахтай холбоотой тогтмол зардлууд хүрэлцэхгүй өр үүсэх төлөвтэй болоод байна. ҮҮНД:

1. Түлш халаалтын зардал жилийн нийт төсөв 7920,0 мянган төгрөг, сард 1204,8 мянган төгрөг төлдөг **/1204.8*7сар=8433.6** / эхний хагас жилд 342,7 мянган төгрөгийн өр үүссэн, төсвийг **513,6** мянган төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай.
2. Тайлант онд Аймгийн засаг даргын захирамжаар тус аймгийн зүүн хойд талыг моджуулах, түүнийг арчилж тордож ургуулах, услалтын ажлыг тухайн байгуулагад нь хариуцуулсан. Үүнтэй холбоотойгоор цэвэр бохир усны зардал хэтэрч байгаа. Цэвэр бохир усны жилийн нийт төсөв 589,4 мянган төгрөг, эхний 8 сарын байдлаар нийт гүйцэтгэл 724,3 мянган төгрөг, сүүлийн улиралд зардлыг **134,9** мянган төгрөгөөр нэмэгдүүлэх.
3. Тус байгууллагын барилга нь дулааны алдагдал ихтэй өвлийн улиралд маш хүйтэн байдаг учраас халаагуур /тень/ залгадаг. Үүний улмаас гэрэл цахилгааны зардал 9,10,11,12 саруудад хэтэрдэг. Гэрэл цахилгааны зардлыг **216,2** мянган төгрөгөөр нэмэгдүүлэх.
4. Шуудан холбоо интернетийн зардал одоогоор өр үүсээгүй боловч төсөвлөсөн хэмжээгээр ирвэл тайлант хугацаанд өр үүсэхгүй, төсөвлөсөн хэмжээгээрээ ирэхгүй бол өр үүсэх магадлалтай. Албаны хэмжээнд 6 ш суурин утастай /6*6050=36.3 мянган төгрөг/ эдгээр утасны төлбөрт /6*10,0=60.0 мянган төгрөг/ интернет 103,4 мянган төгрөг, сарын нийт төлбөрт 160,0-190,0 мянган төгрөг төлдөг. Жилийн нийт төсөв 3184,4 мянган төгрөг, эхний 8 сарын байдлаар 1541,6 мянган төгрөг зарцуулаад байгаа. 12-р сарын төсвийг 9,10,11,12 саруудад жигд хувааж тавиулах шаардлагатай байна.
5. Төсвийн хуваарийг харгалзан үзэж төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж өгөхийг хүсэж байна.

ЗАХИРГАА, ХУУЛИЙН ТАСГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНГӨНЦЭЦЭГ